

ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ГАВАА ОВОГТОЙ ДАШБАЛДАНГЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.07.24.

УРИА: **ДУНДГОВЬ НУТГИЙНХАА ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ**

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2018-2028 дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр”, зэрэг бодлогын баримт бичгүүдэд суурилан иргэдийн амьдрах орчныг сайжруулж, орон нутагтаа ая тухтай сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 4 үндсэн бүлэг, 12 дэд бүлэг, 22 зорилт бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.

НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Эрүүл, боловсролтой иргэн
- 1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах
- 1.3. Хүүхэд, гэр бүл залуучууд, ахмадын хөгжлийг дэмжинэ

ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 2.1 Мэргэшсэн чадварлаг, хүнд сурталгүй төрийн алба
- 2.2 Шилэн тендерийг зохион байгуулна.
- 2.3 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

- 3.1. Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг сайжруулна
- 3.2. Бэлчээрийн менежментийг сайжруулж, мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулахад анхаарна
- 3.3. Хүнсний бичил тариаланг дэмжинэ

ДӨРӨВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ
- 4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.
- 4.3 Сумын төвийн шинэчлэлийг хэрэгжүүлж ажиллана

НЭГ. ИРГЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1 Эрүүл, боловсролтой иргэн.

1.1.1. Эмч, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд санаачилгатай ажиллана.

1.1.2. Нийгмийн эрүүл мэндийг хөгжүүлэх чиглэлд анхаарна.



1.1.3. Эрүүл мэнд, боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.

1.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах

1.2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэргээн засах чиглэлд анхаарч ажиллана.

1.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сурах эрхийг хангахад идэвхтэй ажиллана.

1.3.Хүүхэд, гэр бүл залуучууд ,ахмадын хөгжлийг дэмжинэ.

1.3.1 Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг ажиллана.

1.3.2 Гэр бүл, хүүхэд, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин нөхцөлийг бий болгоно.

1.3.3 Ахмадын хөгжлийг дэмжиж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

1.3.4. Хүүхдийг ахуйн болон замын ослоос урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

ХОЁР. САЙН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

2.1 Мэргэшсэн чадварлаг төрийн алба

2.1.1. Төрийн албанд мэргэшсэн чадварлаг албан хаагчид ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжиж ажиллана.

2.1.2. Төрийн албаны хүнд суртал,авилга, хээл хахуулийг таслан зогсоохын төлөө ажиллана.

2.2 Шилэн тендерийг зохион байгуулна.

2.2.1 Төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа /Тендер/-г нээлттэй ил тод шилэн болгоно.

2.3 Хариуцлагатай уул уурхайг бий болгоно.

2.3.1. Уул уурхайн төслүүдийн нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

2.3.2. Хүн, амьтан,байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх уул уурхайг хязгаарлаж, хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх бодлогыг баримтална.

ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГО

3.1 Малаас гарах бүтээгдэхүүний үр өгөөжийг нэмэгдүүлж, малчдын амьжиргааг сайжруулна.

3.1.1. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, зах зээлд борлуулах төсөл хөтөлбөрийг санаачлах болон дэмжиж ажиллана.

3.2. Бэлчээрийн менежментийг сайжруулж, мал эмнэлгийн үйлчилгээг чанаржуулахад анхаарна



3.2.1. Мал эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд анхаарна

3.2.2. Бэлчээрийн менежментийг сайжруулна.

3.3. Хүнсний бичил тариаланг дэмжинэ

3.3.1. Иргэн, өрх, аж ахуйн нэгжийн хүнсний бичил тариалан/Хүлэмжийн аж ахуй/-г хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

ДӨРӨВ. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

4.1 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ

4.1.1 Иргэд, өрх, аж ахуйн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж, туслах аж ахуй эрхлэх санал санаачлагыг дэмжинэ.

4.2 Төрөлжсөн аялал жуулчлал бий болгоно.

4.2.1. Орон нутгийн жуулчны баазуудын дэд бүтцийг сайжруулж, ая тухтай орчин бүрдүүлж, олон улсын жишигт нийцүүлэхэд анхаарна.

4.2.2. Жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор уламжлалт зан заншил, соёл урлаг, нутгийн онцлогтой бүтээгдэхүүн үйлчилгээ / Айрагны баяр, тэмээний баяр, Ардын урлагийн наадам г.м/-г сурталчлах эвент арга хэмжээг дэмжинэ.

4.3. Сумын төвийн шинэчлэлийг хэрэгжүүлж ажиллана.

4.3.1. Сумын төвийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд санаачлагатай ажиллана.

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ *Г. Дашбалдан* Г. Дашбалдан

ХАЯГ: Дундговь, Сайнцагаан 7-р баг 409 -3

УТАС: 86182121

РД: 3П56090319

